



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/524

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Заан цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэх анхны барилдаан зохион байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан дээрх 11 дэх удаагийн үндэсний бөхийн барилдааныг Эрдэнэт хотод 2017 оны 09 дүгээр сарын 23,24-ний өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Барилдааныг зохион байгуулахад шаардагдах 5000000 /Таван сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Монгол улсын заан цолтнуудад хүндэтгэл үзүүлэх барилдааныг зохион байгуулах зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Үндэсний бөхийн барилдааныг өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсэг /н.Түвшинжаргал/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 524 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗААН ЦОЛТОЙ БӨХЧҮҮДӨД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ
АНХНЫ БАРИЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙ,
УЛАМЖЛАЛТ 11 ДЭХЬ УДААГИЙН БАРИЛДААНЫ
ТӨСӨВ

Д/д	Даваа	Ажиллах өдөр	Хүний тоо	Шагнал	Мөнгөн дүн
128 бөх					
1	1 давсан		32	10000	320000
2	2 давсан		16	25000	400000
3	3 давсан		8	60000	480000
4	4 давсан		4	130000	520000
5	5 давсан		2	400000	800000
6	6 давсан		1	700000	700000
7	7 давсан		1	1000000	1000000
	Дүн				4220000
Шүүгч					
1	Ерөнхий шүүгч	1	1	25000	25000
2	Нарийн бичгийн дарга	1	2	25000	50000
3	Хаяавч	1	1	15000	15000
4	Засуул	1	8	20000	160000
5	Хөлийн цэц	1	2	20000	40000
6	Эмч	1	1	20000	20000
7	Тайлбарлагч	1	1	20000	20000
8	Идээний шүүгч	1	1	20000	20000
9	Үзель	1	1	20000	20000
	Дүн				370000
Бусад					
1	Өргөмжлөл	ш	4	30000	120000
2	Медаль	ш	4	25000	100000
3	Айраг	л	50	3000	150000
4	Боорцог	кг	20	2000	40000
	Дүн				410000
	Төсвийн дүн				5000000